



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/288

Хэрлэн сум

Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, ойн арга хэмжээ зохион байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 1.4 дэх хэсэг, 5.1 дэх хэсэг, 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, Чөлөөлөх дайны 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, эх орны сэдэвт үйл ажиллагаа, эссэ бичлэгийн уралдаан тэмцээнийг үе шаттайгаар зохион байгуулсугай.

2.Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинтэй холбоотой үйл ажиллагааг сурталчлах, тэмдэглэн өнгөрүүлэхэд 9,990,400 (есөн сая есөн зуун ерэн мянга дөрвөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай

3.Үйл ажиллагааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


4.Үйл ажиллагаатай холбоотой зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж дүн мэдээг илтгэхийг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Л.Цэнддорж)-д, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ



231010891



АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн
ахлагч:

А.Жаргалсайхан Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Орлогч
дарга:

Л.Цэнддорж Цэргийн штабын дарга дэд хурандаа

Нарийн бичгийн
дарга:

Г.Батгэрэл Цэргийн штабын тоо бүртгэлийн
ахлах офицер дэд хурандаа

Гишүүдэд:

М.Бат-Очир Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн
захирагч хурандаа

Б.Түмэнжаргал Нийгмийн бодлогын хэлтсийн даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Мөнхцэцэг Боловсролын газрын дарга

Г.Солонго Биеийн тамир, спортын газрын
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Батсайхан Монгол цэргийн нэгдсэн холбооны
Хэнтий аймаг дахь салбар холбооны
нарийн бичгийн дарга